

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Жаргалант сумын 10 дугаар Цэцэрлэгийн 2021 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн  
аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/79/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Л.Галбадрах

Утас: 70432545

цахим хаяг: galbadrah.L@ audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СУМЫН 10 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ А.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

дод. од. д/д № 2/49  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын 9 дүгээр Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Жаргалант сумын 10 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлэн гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>35762387.0</u></b>	<b><u>43572312.1</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	0.0	96013.1
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	96013.1
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	35762387.0	43476299.0
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	2133200.0	1537300.0
35130	Эм боох материал	2133200.0	1537300.0
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	33629187.0	41938999.0
35410	Бичиг хэргийн материал	36000.0	705800.0
35420	Аж ахуйн материал	232000.0	417532.0
35440	Түлш, шатах тослох материал	1335000.0	300000.0
35450	Барилгын засварын материал	70000.0	0.0
35460	Хүнсний материал	764180.0	893860.0
35470	Бусад хангамжийн материал	31192007.0	39621807.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>471540824.2</u></b>	<b><u>1568925375.6</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	471540824.2	1568925375.6
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	392944399.2	1490443200.6
39201	Барилга, байгууламж, орон сууц	389621309.8	1512920045.8
39202	Хуримтлагдсан элэгдэл	-33847607.6	-47987335.7
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	56273415.0	51469815.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38674624.3	-39646165.0
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50946042.0	46740942.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39034927.4	-39697268.2
39214	Бусад үндсэн хөрөнгө	8000000.0	8000000.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-339208.3	-1356833.3
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	78596425.0	78482175.0
39301	Програм хангамж	457000.0	457000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-171375.0	-285625.0
39303	Бусад биет бус хөрөнгө	78310800.0	78310800.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>507303211.2</u></b>	<b><u>1612497687.7</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>507303211.2</u></b>	<b><u>1612497687.7</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	507303211.2	1612497687.7
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	253704289.0	253704289.0
51101	Өмч: - төрийн	253704289.0	253704289.0
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-59303723.5	1045890752.9
51210	Өмнөх үеийн үр дүн	-59303723.5	-59303723.5
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	1105194476.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	312902645.8	312902645.8

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>507303211.2</b>	<b>1612497687.7</b>
---	--	--------------------	---------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>434101000.0</b>	<b>1578965818.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3499000.0</b>	<b>1137538436.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3499000.0	1135038436.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3499000.0	1135038436.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3499000.0	1135038436.0
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	0.0	2500000.0
122001	Хандив тусламж /дотоод/	0.0	2500000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>430602000.0</b>	<b>441427382.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	391385400.0	405252400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	391385400.0	405252400.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.0	9581082.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	9401082.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	180000.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	39216600.0	26593900.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.0	26593900.0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	39216600.0	0.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>450733786.5</b>	<b>471990091.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>450733786.5</b>	<b>471990091.5</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	426300091.4	425402796.5
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	307542644.0	310107621.0
210101	Үндсэн цалин	267155861.0	232864835.0
210102	Нэмэгдэл	11245212.0	50609435.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2560000.0	1927500.0
210104	Урамшуулал	26581571.0	24705851.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38979931.9	40207005.9
210201	Тэтгэврийн даатгал	26689839.7	27800830.2
210202	Тэтгэмжийн даатгал	3079626.4	3113676.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	2463701.2	2490941.0
210204	Ажилгүйдлийн даатгал	613342.2	618323.5
210205	Эрүүл мэндийн даатгал	6133422.3	6183235.0

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25208384.0	27343025.0
210301	Гэрэл, цахилгаан	5045944.0	1901025.0
210302	Түлш, халаалт	10853000.0	12785000.0
210303	Цэвэр, бохир ус	9309440.0	12657000.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1185650.0	1572500.0
210401	Бичиг хэрэг	525050.0	699300.0
210402	Тээвэр, шатахуун	92600.0	300000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	101000.0	320200.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.0	225000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12000.0	28000.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	455000.0	0.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	25012820.0	15103210.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	497250.0	800500.0
210502	Хоол, хүнс	22959370.0	13607410.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1556200.0	695300.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1098700.0	1946200.0
210604	Урсгал засвар	1098700.0	1946200.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.0	371000.0
210702	Дотоод албан томилолт	0.0	371000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	432000.0	492000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	60000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432000.0	432000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	26839961.5	28260234.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	414900.0	315000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26425061.5	27945234.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	24433695.1	46587295.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.0	8722650.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	8722650.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	24433695.1	37864645.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24433695.1	37864645.0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-16632786.5</b>	<b>1106975726.5</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	0.0	0.0
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	0.0	1781250.0
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.0	1781250.0
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	0.0	-1781250.0
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-16632786.5</b>	<b>1105194476.5</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	253,704,289.0	312,902,645.8	(59,303,723.5)	507,303,211.2
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>253,704,289.0</b>	<b>312,902,645.8</b>	<b>(59,303,723.5)</b>	507,303,211.2
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(5,883,972.6)	(5,883,972.6)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>253,704,289.0</b>	<b>312,902,645.8</b>	<b>(65,187,696.1)</b>	501,419,238.6
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>253,704,289.0</b>	<b>312,902,645.8</b>	<b>(65,187,696.1)</b>	501,419,238.6
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>253,704,289.0</b>	<b>312,902,645.8</b>	<b>(65,187,696.1)</b>	501,419,238.6
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,105,194,476.5	1,105,194,476.5
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>253,704,289.0</b>	<b>312,902,645.8</b>	<b>1,040,006,780.3</b>	1,606,613,715.1

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>430602000.0</b>	<b>443927382.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.0</b>	<b>2500000.0</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	0.0	2500000.0
122001	Хандив тусламж /дотоод/	0.0	2500000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>430602000.0</b>	<b>441427382.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	391385400.0	405252400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	391385400.0	405252400.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.0	9581082.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	9401082.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	180000.0
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	39216600.0	26593900.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.0	26593900.0

132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	39216600.0	0.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>430602000.0</b>	<b>443927382.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>430602000.0</b>	<b>443927382.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>406168304.9</b>	<b>397340087.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	307973454.0	310107621.0
210101	Үндсэн цалин	164645380.0	184661683.0
210102	Нэмэгдэл	118276489.0	100290650.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2794090.0	1927500.0
210104	Урамшуулал	22257495.0	23227788.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38514907.9	40303019.0
210201	Тэтгэврийн даатгал	26066707.9	28539384.6
210202	Тэтгэмжийн даатгал	3087600.0	2957937.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2470000.0	2366349.8
210204	Ажилгүйдлийн даатгал	715500.0	585395.2
210205	Эрүүл мэндийн даатгал	6175100.0	5853952.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26712793.0	26308025.0
210301	Гэрэл, цахилгаан	5045944.0	1901025.0
210302	Түлш, халаалт	12357409.0	11750000.0
210303	Цэвэр, бохир ус	9309440.0	12657000.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1991850.0	2187932.0
210401	Бичиг хэрэг	333350.0	927300.0
210402	Тээвэр, шатахуун	92600.0	300000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	101000.0	59400.0
210404	Ном, хэвлэл	70300.0	23700.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.0	678432.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1394600.0	199100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	27477850.0	14426690.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2723900.0	65900.0
210502	Хоол, хүнс	23025250.0	13737090.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1728700.0	623700.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1643400.0	1961200.0
210604	Урсгал засвар	1643400.0	1961200.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.0	85200.0
210702	Дотоод албан томилолт	0.0	85200.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	559600.0	575600.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	127600.0	143600.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432000.0	432000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1294450.0	1384800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1294450.0	1384800.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24433695.1</b>	<b>46587295.0</b>

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.0	8722650.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	8722650.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	24433695.1	37864645.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24433695.1	37864645.0
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.0	0.0
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0.0	0.0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	444946300.0	393981655.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	444946300.0	393981655.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	444946300.0	393981655.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	311164500.0	310107621.0
210101	Үндсэн цалин	190171100.0	184661683.0
210102	Нэмэгдэл	97844800.0	100290650.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2402700.0	1927500.0
210104	Урамшуулал	20745900.0	23227788.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	42007200.0	40303019.0
210201	Тэтгэврийн даатгал	29560600.0	28539384.6
210202	Тэтгэмжийн даатгал	3111400.0	2957937.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2489400.0	2366349.8
210204	Ажилгүйдлийн даатгал	622400.0	585395.2
210205	Эрүүл мэндийн даатгал	6223400.0	5853952.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	39483900.0	26308025.0
210301	Гэрэл, цахилгаан	14895900.0	1901025.0
210302	Түлш, халаалт	11931000.0	11750000.0
210303	Цэвэр, бохир ус	12657000.0	12657000.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	987500.0	760700.0
210401	Бичиг хэрэг	109300.0	178500.0
210402	Тээвэр, шатахуун	526800.0	300000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	89800.0	59400.0
210404	Ном, хэвлэл	62500.0	23700.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	199100.0	199100.0

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	49199600.0	14426690.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65900.0	65900.0
210502	Хоол, хүнс	48510000.0	13737090.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	623700.0	623700.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	210000.0	210000.0
210604	Урсгал засвар	210000.0	210000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	113200.0	85200.0
210702	Дотоод албан томилолт	113200.0	85200.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	575600.0	575600.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143600.0	143600.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432000.0	432000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1204800.0	1204800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1204800.0	1204800.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	444946300.0	393981655.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	405252400.0	367463630.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	405252400.0	367463630.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	39693900.0	26518025.0
132001	Орон нутгийн төсвөөс	39693900.0	26518025.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>12081082.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>12081082.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	3358432.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	1427232.0
210401	Бичиг хэрэг	-	748800.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	678432.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	1751200.0
210604	Урсгал засвар	-	1751200.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	180000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	180000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	8722650.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	8722650.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8722650.0
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	9581082.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	9581082.0

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9401082.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	180000.0
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын 10 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Л.Галбадрах 2022 оны 02 дүгээр сарын 01-нээс 2022 оны 02 дугаар сарын 14-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

\

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Жаргалант сумын 10 дугаар Цэцэрлэгийн “Хүүхдийн хөгжлийг тасралтгүй үргэлжлүүлэн багш ажлын байран дээрээ хөгжин бусдад туршлагаа түгээн дэлгэрүүлэн ажиллах, олон нийтийн оролцоонд тулгуурлан эцэг эх, асран хамгаалагчтай хамтран тойргийн хүүхдийг тэгш хамруулан сургах ажлыг зохион байгуулахад анхаарч Хүүхэд бүр цэцэрлэгт, Гараас гарт, Монгол хэл бичиг, Тогтвортой хөгжлийн боловсрол, Чадварлаг багш дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах зорилго дэвшүүлж үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Монгол улсын үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай, түүнд нийцүүлэн гаргасан хуулийг баримталж иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Жаргалант сумын 10 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 471.9 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 4.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Ховд аймгийн Жаргалант сумын 10 дугаар Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1105.1 сая төгрөгөөр буюу 17.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Тайлант оны эцэст 0.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл нь нийгмийн даатгалын шимтгэлтэй үүссэнтэй холбоотой байна.

Тайлант оны эцэст 0.1 сая төгрөгийн өглөгтэй байна. Энэ нь татвартай холбоотой үүссэн өглөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 43.4 сая төгрөг болж 7.7 сая төгрөгөөр буюу хангамжийн материалын үлдэгдлээр өссөн байна. Тайлант хугацаанд үнэ төлбөргүйгээр 1127.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 30.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 43.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 583.6 сая төгрөг, оны эцэст 1697.8 сая төгрөг болж 1114.2 сая төгрөгөөр өссөн нь Жаргалант сумын 10 дугаар Цэцэрлэгийн барилга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн холбоотой байна.

Тайлант онд 1127.1 сая төгрөгийн үнэ төлбөргүйгээр хөрөнгө хүлээн авч, 3.1 сая төгрөгийн хөрөнгө акталж тайлант оны эцэст 1697.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 507.3 сая төгрөг байсан оны эцэст 1612.4 сая төгрөг болж тайлант онд 1105.1 сая төгрөгөөр өссөн нь шинээр хөрөнгө оруулалтаар хийгдсэн байр бүртгэсэн, тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1045.8 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Ховд аймгийн Жаргалант сумын 10 дугаар Цэцэрлэгийн оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 393.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 393.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 393.9 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 393.9 сая төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 405.2 сая, орон нутгийн төсвөөс 26.5 сая төгрөг авч, 37.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж 393,9 сая төгрөгийн төсвийн зардал гаргасан байна.

Улсын төсвөөс 37.8 сая төгрөг буюу 10 хувийг хэмнэж зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансаар 12.0 сая төгрөгийг орж ирснийг хөдөө орон нутагт тогтворт суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг тусламжийн зардал, урсгал засварын зардал, хог хаягдал, бичиг хэргийн зардалд тусган зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс 150 мэдээллийг хугацаандаа оруулсан байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 12 ажил гүйлгээг шилэн дансны сайтад д байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Шилэн дансны тухай хуулийн “6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор” гэсэн заалтыг хэрэгжүүлэн хагас жилийн санхүүгийн тайланг шилэн дансны сайтад хугацаанд нь байршуулсан байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон, хүүхдийн хоолны зардлаас ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн, батлагдсан төсвийн хэмнэгдсэн зардлаас албан хаагчдад түлш унаа хоолны хөнгөлөлтийг олгосон зөвлөмж өгсөн байна. Өгсөн зөвлөмжийг тайланд онд бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**  
**Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.**

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар илэрсэн алдаа зөрчил байхгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын 10 дугаар Цэцэрлэг	0	0	0	0			0	0	0	0

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:**

**Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:**

**А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АХЛАХ АУДИТОР:**

**Л.ГАЛБАДРАХ**